



“Сайн санаа”

Булган аймгийн
Орхон сумын БАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 08-02 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, 900000ТӨГ:

Төсөл хэрэгжсэн газар

Булган аймгийн Орхон сум Шувуут багийн Могойт уул БАХ-ын гишүүн Б.Шүрэнцэцэг

Төслийн зорилго

Сүүний чиглэлийн үнээгээ нэмэгдүүлж эдийн засгаа өргөжүүлж аймаг сумынхаа иргэдийг хямд чанартай цагаан идээгээр хангах

Төслийн зорилтууд

- 1.Өрхийн орлого сайжирна
- 2.Малаа тааварлаг чанартай болго

Төслийн хөрөнгө оруулалт.:

Булган аймгийн Орхон сумын Шувуут багийн Могойт уул БАХ-ын гишүүн Б.Шүрэнцэцэг нь цагаан идээ боловсруулж өрхийн аж ахуй эрхэлдэг. Тэрбээр 2 оюутан, 12 ангийн нэг хүүхэдтэй, тэдний сургалтын төлбөр болон хэрэгцээний мөнгийг цагаан идээ боловсруулан зарж орлого олдог. Саалийн 3 үнээтэй байсан. НАМЭМ төслөө хүрээнд БАХ-ын эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр 900,000 мянган төгрөгний буцалтгүй тусламж үзүүлж өөрийн хөрөнгөө нийлүүлж саалийн сүүний чиглэлийн ингэтийн улаан халзан үнээ 5-ыг авч өрхийн аж ахуйгаа өргөжүүлэн ажиллаж байна. Өөрийн хөрөнгө 5 сая 100 мянган төгрөг НАМЭМ-төслөөс буцалтгүй 900 мянган төгрөг, 1 тугалтай үнээг 1сая 200 мянган төгрөг, 5 үнээг 6 сая төгрөгөөр худалдан авч, өрхийн аж ахуйгаа өргөжүүлэн ард иргэдээ хямд үнэтэй чанартай цагаан идээгээр ханган ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1.	Сүүний чиглэлийн үнээ авах	Төгрөг	1	900000	900000
	Нийт				900000

Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1.	Сүү	л	600	1500	900000
2.	Тараг	л	500	1500	750000
3.	Ааруул	кг	50	10000	500000
4.	Бяслаг	ш	20	10000	200000
	Нийт				2350000

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Булган аймгийн Орхон сумын Шувуут багийн Могойт уул БАХ-ын хэсгийн гишүүн

Б.Шүрэнцэцэг нь саалийн 3 үнээтэй цагаан идээ бага зэрэг боловсруулж зарж борлуулдаг байсан ч жил дараалан оюутантай болж байгаа нь амьдралд нь маш хүндрэл учруулсан. Тиймээс өөрийн хөрөнгөө шавхаж мөн НАМЭМ төслөөс дэмжлэг авч саалийн 5 үнээ нэмж авч өөрийн өрхийн хэрэгцээнд 8 саалийн үнээтэй болж эдийн засгийн эргэлтэнд орж аймаг, сум орон нутгийн иргэдэд хямд чанартай цагаан идээгээр ханган ажиллаж байна. Урьд нь 3 үнээтэй байхад сүүний гарц бага цагаан идээ боловсруулахад маш хүндрэлтэй байдаг байсан одоо 8 үнээнээс гарч байгаа сүүний гарц элбэг цагаан идээ боловсруулж байгаа арвин элбэг зарж борлуулахад тун таатай байна. Орхон сум нь Булган аймагтаа ойрхон байдаг нь цагаан идээгээр зарж борлуулахад боломжийн байдаг.

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Булган аймаг, Орхон аймаг, Орхон сумын ард иргэд хямд чанартай цагаан идээ хүртэх боломжтой. Өвлийн улиралд аарц, цагаа ихээр хураан авч, Ковид-19 цар тахлын энэ үед цагаан идээ, мах ихээр идэж дархлаагаа сайжруулж байх нь хэрэгтэй тул аарцны борлуулалт, эрэлт хэрэгцээ нэмэгдсэн. Булган аймгийн 10 мянга гаруй иргэд, Орхон сумын нийт иргэдэд хүртээх боломжтой.



Сүүний чиглэлийн улаан халзан үнээ

